



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/470

Ховд

Эзэмшил газрын хэмжээ, талбай
өөрчлөх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/05 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 55 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Магсаржав багийн Ховд Эко телевизийн байрны урд байрлах Намсрайн Бат-Оршихын /ПЮ63123136/ 94 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 223 метр квадрат, Лааганы 1 дүгээр гудамжны 113 тоот болгон үйлчилгээний зориулалтаар 6 жилийн хугацаагаар өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2.Газрын хэмжээ талбай өөрчлөгдөж байгаа дээрх иргэнд газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/470 Ch
02 02324